



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

### Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 43 /дөчин гурав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 34,452,124 /гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорин дөрөв/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Айтүүлс” ХХК-ийн нэг бүр нь 43 /дөчин гурав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 21,064,144 /хорин нэгэн сая жаран дөрвөн мянга нэг зуун дөчин дөрөв/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг “Ай Си Ти групп” ХХК-ийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчийн өмчлөлд бүртгэсэн хувьцаанаас бусад нийт 13,387,980 /арван гурван сая гурван зуун наян долоон мянга есөн зуун наян/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 100 /нэг зуун/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Айтүүлс” ХХК /И.Алтантулга/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 75 /далан тав/ ба түүнээс дээш хувийг анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд зарагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохыг “Айтүүлс” ХХК /И.Алтантулга/-д мэдэгдсүгэй.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

6. “Айтүүлс” ХХК нь хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрэм хэлбэрийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Айтүүлс” ХХК /И.Алтантулга/-д үүрэг болгосугай.

7. “Айтүүлс” ХХК-д үнэт цаасаа нийтэд санал болгон гаргахад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхдээ өмнө удаа дараа гаргасан алдаагаа давтахгүй ажиллахыг “Стандарт инвестмент ҮЦК” ХХК /Ч.Жаргал/-д сануулж, энэ тогтоолын 4-т заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдсүгэй.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН